

ДУРДАТГАЛ
БОДОЛ

**УЛАМЖЛАЛТ НАЙРАМДАЛ
УЛАМ БЭХЖИНЭ**

БНМАУ-ын гавьяат жүжигчин,
төрийн шагналт **Л. Цогзолмаа**

1953 онд манай монголын 100 гаруй хүний бүрэлдэхүүнтэй урлагийн томоохон хэсэг БНХАУ-д зочилон тоглолт хийсэн юм. Бид бүтэн 2 сар шахам Бээжин, Ханжоу, Гуанжоу, Шанхай, Харбин, Хөх хот зэрэг хятадын томоохон 10 гаруй газарт тоглолт хийсэн. Манай тоглолтыг хятадын ард түмэн элэгсэг дотноор хүлээн авч, биднийг хүндэтгэн зочилж байлаа. Биднийг Бээжин хотод яг л төрийн тэргүүн угтаж байгаа юм шиг галт тэрэгний буудлаас хотын төв хүртэл замын хоёр талаар жагссан хүмүүсийн дундуур явуулж баяр хүргэж байлаа. Бээжингийн гудамжинд маршал Чойбалсан, «Учиртай гурван толгой» дуурийн Юндэн, Нансалмаа нарын зургийг томоор зурж өлгөсөн байсан. Тэр үед БНХАУ байгуулагдаад дөрөвхөн жил болж байв. Манай хоёр орны харилцаа маш сайн байсан. Бидэнд хятадын газар нутаг дээр хөл тавьсан анхны мөчөөс эхлээд л Хятадын ард түмний ажилсаг хичээнгүй, хөдөлмөрч шинж чанар ажиглагдсан юм. Бүх газар нутагтаа тариа тарьж, нэг метр ч чөлөөтэй газар харагдахгүй агаад зүгээр сууж байгаа хүн ер үгүй байсан шиг санагдана. Бидэнтэй хамт хоёр сарын турш Пунцагдорж, Сайнцогт гэдэг хоёр өвөр монгол нөхөд орчуулагчаар ажиллаж, гадаад яамны ажилтан Тинко, Ли Гуо, мөн эмч, үйлчлэгч олон хүн явж байсан билээ.

Манай тоглолтод Цэцэнтархи, Жугавэнь гэдэг хоёр төгөлдөр хуурч, орж бидэнд их туслаж байсан. Цэцэнтархи жижигхэн биетэй хөөрхөн царайтай охин байсан болохоор манайхан түүнд «Би хөөрхөн тоть доо» гэж зааж өгчихөөд хэлүүлээд л байдаг сан. Эмч залуу маань манай хөгжмийн нэрт зохиолч Мөрдоржтой их адилхан царайтай болохоор нь Муёо гэж дууддаг байсан юм. Бидний буусан зочид буудлын хашааны хаалганы голд нэг сайхан том улиас байсан нь автобус орж гарахад саад болоод байхад нь түүнийг хөрөөдөж авсан юм. Манайхан ийм сайхан модыг хөрөөдөж яах нь вэ гэхэд Тинко дарга маань, энэ мод хятад-монголын найрамдалд саад болж байна гэж тоглон инээж байж билээ. Ийм сайхан ах дүүсэг харилцаа маань дахин сэргэж байгаад бид бүхэн их баяртай байна. Хятадын ард түмэн манай тоглолтыг маш их сонирхон, олон мянган хүний суудалтай хүрээлэнд хуран цугларсан үзэгчид итгэл, найдвар, найрсаг сайхан сэтгэлээр хүлээн авч байсан нь биднийг зоригжуулж баярлуулж байсан билээ. Бидний тоглолтын тухай хятадын сонин хэвлэлд тасралтгүй бичиж байв. Бид ч хятадын ард түмний олон мянган жилийн түүхт дурсгалуудтай танилцаж, бас алдарт жүжигчин Мэй Ланьфаны тоглолтыг үзэж, түүнтэй уулзаж ярилцсанаа мартдаггүй юм. Биднийг Бээжин хотоос гаргаж өгөх гэж олон арван хүн шиврээ бороонд бөмбөр цангаа цаг шахам тасралтгүй цохиж баяр талархал хүргэж байсан нь одоо ч нүдэнд илхэн байна. Муу юм арилж сайн бүхэн ялж байх жамтай болохоор манай хоёр орны сайн харилцаа сэргэж уламжлалт найрамдал улам бэхжинэ гэдэгт итгэж байна.